

Байгаль орчны менежментийн ТӨЛӨВЛӨГӨӨ 2025

**ӨМНӨГОВЬ АЙМАГ, МАНДАЛ-ОВОО СУМ
БУРХАН ДЭЛ АЛТНЫ ҮНДСЭН ОРД АШИГЛАХ ТӨСӨЛ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ MV-016759**

МАНДАЛ РЕСУРС ХХК

Утас +976 89002995
Факс + 976 77733355

Хаяг: Авзага оффис, 3 давхар
Энхтайваны өргөн чөлөө
Сүхбаатар дүүрэг 1-р хороо
Улаанбаатар хот

Цахим шуудан
environment@mandalresource.mn

Батлав.

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны бодлого
зохицуулалтын газрын дарга

Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
МАНДАЛ РЕСУРС ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Г.Дашдэндэв

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАНДАЛ-ОВОО
СУМЫН ХОРИМТ НЭРТЭЙ ГАЗАРТ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “БУРХАН
ДЭЛ АЛТНЫ ҮНДСЭН ОРД АШИГЛАХ”
ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-016759 /

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 5699134/

Хянасан:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны бодлого
зохицуулалтын газрын мэргэжилтэн

.....

Боловсруулсан:

МАНДАЛ РЕСУРС ХХК-ийн

ХЭМАБ-БОХ-н Ахлах мэргэжилтэн

Сүх-Очир

Г.Сүх-Очир

Агуулга:

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
А. Уулын хэсэг	3
В. Үйлвэрийн хэсэг	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	8
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	16
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	19

Хүснэгтийн жагсаалт:

Хүснэгт 1.	Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	2
Хүснэгт 2.	Уурхайн солбилцол	3
Хүснэгт 3.	Уурхайн календарчилсан төлөвлөлт	4
Хүснэгт 4.	Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	7
Хүснэгт 5.	Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал	8
Хүснэгт 6.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
Хүснэгт 7.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ...	12
Хүснэгт 8.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 9.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт 10.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 11.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
Хүснэгт 12.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	18
Хүснэгт 13.	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	19

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Өмнөговь аймгийн мандал-овоо сумын нутаг дэвсгэрт “мандал ресурс” ххк-ийн mv-016759 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “бурхан дэлийн алтны үндсэн орд” ашиглах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уг төслийн техник эдийн засгийн үндэслэлийг (тэзү) “эм эс эл ти” ххк боловсруулсан бөгөөд 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэзү хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “шүрэн завъяа” ххк 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 13/5633 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлтийн дагуу боловсруулж байгаль орчин, аялал жуулчлалын яамны байгаль орчны стратеги үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, уул уурхай, хүнд үйлдвэрийн төслийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр тайланг хэлэлцүүлэн батлуулсан.

Төлөвлөгөөний нэр: бурхан дэлийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “мандал ресурс” ххк

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга


№	Үзүүлэлтүүд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Мандал ресурс” ххк
2	Улсын бүртгэлийн дугаар	9011405030
3	Уурхайн нэр	Бурхан дэлийн алтны үндсэн орд
4	Ордын байршил	Нийслэл/хот/ аймаг
5		Сум/дүүрэг
6	Ашигт малтмалын төрөл	Алтны үндсэн
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-016759
8	Ашиглалт эхэлсэн огноо	2024
9		Аймаг/хот
10		Сум/дүүрэг
11	Аж ахуйн нэгжийн хаяг	Баг/хороо
12		Гудамж/байр
13		Гар утас
14	Захирлын хаяг	Нэр
15		Гар утас

Төслийн байршил: “Бурхан дэлийн алтны үндсэн орд нь засаг захиргааны хувьд өмнөговь аймгийн мандал-овоо сумын баянхошуу багийн нутаг дэвсгэрт сумын төвөөс баруун урагшаа 40км –т орших бурхан дэлийн уулын өвөрт, улаанбаатар хотоос баруун урагш 650км –т аймгийн төв даланзадгад хотоос баруун хойш 120км –т байрлана.

Уг орд нь газарзүйн байршлын хувьд говийн бүсэд, ханын хэцийн тогтоцын баруун хэсэгт, онги голын төгсгөлөөс 40 орчим км зайд байрлаж байна. Талбайн хэмжээ нь 450.73 га бөгөөд талбайн солбицолын цэгүүдийг хүснэгт №2-д, байршлыг зураг №1-д тус тус үзүүлэв.

- Засаг захиргаа: өмнөговь аймаг, мандал-овоо сум
- Ашигт малтмалын үндсэн төрөл: алтны үндсэн орд
- Талбайн нийт хэмжээ: 450.73 га

№	Газарзүйн солбицол			Уртраг		
	Өргөрөг			Уртраг		
1	104	5	21.1	44	21	50
2	104	3	31.1	44	21	50
3	104	3	31.1	44	22	50
4	104	5	21.1	44	22	50



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

Уулын хэсэг

МГ-ын даргын 2010 оны 07 дугаар сарын 5-ны өдрийн 264 дугаар тушаалаар Бурхан дэлийн алтны үндсэн ордын геологийн нөөцийг В зэрэглэлээр 2380 кг-аар, С зэрэглэлээр нөөцийг 2396.8 кг-аар тус тус улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Ордын хүдрийн биет нь гадарга дээр ил гарштай, тогтвортой зузаантай байдаг. Төслийн уурхайн ашиглалтын системийг ил уурхайн авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгасан.

Орд ашиглах тусгай зөвшөөрөл: өмнөговь аймгийн мандал-овоо сумын нутагт орших “бурхан дэл” нэртэй 450.73 га талбай бүхий ашигт малтмалын mv-016759 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг “мандал ресурс” ххк-д 30 жилийн хугацаатай олгосон байна.

Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, үйлдвэрлэлийн нөөц: уурхайн хэмжээнд үйлдвэрлэлийн в нөөц 1,455.2 мян.тн хүдэр, хүдэр дэх алтны дундаж агуулга 1.12 гр/тн байна. “ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын дагуу уг орд нь ii бүлэгт хамаарч байгаа тул батлагдсан в зэргийн нөөцөд тулгуурлан ил уурхайн оновчлол хийсэн учир с нөөц өртөхгүй.

Төслийн хүчин чадал: 2025 онд уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллах ба ээлж солилцох хугацаа 2 цаг, бүтээлтэй ажиллах хугацаа 20 цаг байна. Уурхайд өмнөх онд ашигласан техник тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд ордын үлдсэн нөөц болох 697 мян.тн хүдэр олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

2025 оны уурхайн календарчилсан төлөвлөлт

Хүснэгт 3. Уурхайн календарчилсан төлөвлөлт

№	Үзүүлэлт нэр	2025 он олборлох хэмжээ
2	Уулын цул, мян. м3	3,401.76
4	Нийт хөрс хуулалт, мян. м3	3,188,95
6	Хөрс хуулалтын итгэлцүүр, тн/тн	12,94
8	Нийт хүдэр олборлолт, мян. м3	697.1
13	алтны агуулга, г/т	1.7
17	Нийт олборлох металлын хэмжээ, кг	745.8


Үйлвэрийн хэсэг

Алтны үндсэн ордын хүдрээс алтыг ялган баяжуулах олон технологи байдгаас бага агуулгатай хүдрийн хувьд хамгийн түгээмэл ашиглагддаг технологи нь нуруулдан уусгах технологи болно. Цианид ашиглан алт уусгах арга нь түүний хямд үнэ болон алт, мөнгийг сонгомол хэлбэрээр уусгах чадварт үндэслэгдсэн. Харин агуулга өндөртэй алтны хүдрийг гравитаци-гангийн уусгалт хосолсон технологиор баяжуулбал илүү эдийн засгийн хувьд үр ашигтай байдаг.



“Бурхан дэл” алтны үндсэн ордын үйлдвэрлэлийн нөөц нь 1,455,246 тн хүдэр ба үүнээс $au > 2$ гр/тн агуулгатай хүдрийн хэмжээ 198,447.5 тн юм.


Иймээс технологийн туршилтын үр дүн болон төсөл захиалагч компанийн санал болгосны дагуу $au > 2$ гр/тн агуулгатай хүдрийг гравитаци-гангийн уусгалт хосолсон, $au < 2$ гр/тн агуулгатай хүдрийг нуруулдан уусгахаар баяжуулах үйлдвэрийн төлөвлөлтийг боловсруулав.

Хэдийгээр цианид натрийн хоруу чанар нь анхаарал татах асуудал боловч уг урвалжийг технологийн горимын дагуу, зөв зохистой ашигласан тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөгүй, эрсдэл багатай байж болно. Энгийн цианидын давс буюу натрийн цианид нь усанд уусч диссоциацлагдан тухайн металлын давс, чөлөөт цианидын ионыг үүсгэдэг.



Цианжуулалтын үед алт нь хүчилтөрөгчөөр исэлдэж улмаар $[au(cn)_2]^-$ -гэсэн комплекс анионы байдлаар уусмалд шилжинэ. Энэ урвалыг дараах байдлаар илэрхийлнэ.





Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн хүдэр бэлтгэх хэсгийн технологийн схем

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газарзүйн нөхцөл: тус сум нь дундговь аймгийн дэлгэрхангай, сайхан-овоо, өвөрхангай аймгийн төгрөг, баянгол, богд сумдтай хил залган оршдог ба 6424 кв.м нутагтай. Хяр толгод, тал хөндий хосолсон үзэсгэлэнт сайхан газар нутагтай. Ханийн хэц, алгуй улаан цав, дөрвөн дэрт зэрэг хэц нуруудтай. Газрын хөрсөндөө шаазан ваарны шавар, усан болор, утаат болор, шохойн чулуу, алт болон чүнчигноров зэрэг ашигт малтмалтайгаас гадна эрт галавийн үеийн аварга гүрвэл, мөлхөгчдийн үлдэгдэл, чулуужсан мод зэрэг ховор олдвортой. Мөн хангайн аймгаас 350 гаруй км урсаж байгаа онгийн гол нь тус сумын нутгаар 140 км урсаж улаан нуурт цутгадаг онцлогтой. “мандал ресурс” ххк-ийн “алтны үндсэн орд ашиглах” төслийн талбай нь сумын төвөөс баруун зүгт 35 км зайд байрлах ба тус талбайн ойр орчмын газар нутаг нь монгол орны физик газарзүйн мужлалаар хуурай уур амьсгалтай говийн бүслүүрт хамаарагддаг.

Уур амьсгал: мандал-овоо сум орчмын нутаг нь цөлөрхөг хээрийн хуурай уур амьсгалтай, агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас багатай зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалтай. Сар болон өдрийн агаарын хэмийн өөрчлөлт эрс ялгаатай. Зун нь уртавтар, маш халуун бөгөөд өвөл нь богинохон, хүйтэвтэр байдаг онцлогтой бүс нутаг юм. Тухайн бүс нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын төрх зэргээс хамааран улирлын шинж газар бүрт харилцан адилгүй байдаг. Энэ бүс нутагт жилийн ихэнх хугацаанд буюу дунджаар 219 хоногт нь дулаан байдаг ба үлдсэн 146 хоногт хүйтэн байдаг

Усан орчин: төслийн талбай орчмын нутаг дэвсгэр нь төв азийн гадагш урсгалгүй ай савд, умард говийн гүвээт халхын дундад тал сав газарт хамаарах бөгөөд монгол орны хамгийн гантай дүүргийн нэг юм.

Хөрс, ургамал: “мандал ресурс” ххк-ийн “алтны үндсэн орд ашиглах” төсөл хэрэгжих өмнөговь аймгийн мандал-овоо сумын нутагт нь хөрс-газарзүйн мужлалын төв азийн их мужийн говийн мужийн өргөргийн бүсшилийн хээржүү цөлийн бор хөрсний 8-р тойрогт багтана. Төсөл хэрэгжих бүс нутаг нь монгол орны ургамал-газарзүйн мужлалаар дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтана.

Амьтны аймаг: мандал-овоо орчмын нутаг нь монгол орны хөхтөн амьтдын тархцын мужлалаар хойд говийн тойрогт хамаарагдаж байна. Өмнөх (эко трейд ххк, 2009) судалгаанаас үзэхэд мандал-овоо орчмын нутаг дэвсгэрт хөхтөн, шувуу, мөлхөгчдийн гэх 3 ангид хамаарах 42 зүйлийн сээртэн амьтад бүртгэгдсэн байна.

Нийгэм, эдийн засаг: засаг захиргааны төвүүд нь Улаанбаатар хоттой засмал болон шороон замаар холбогдсон. Утсан харилцаа сайн хөгжсөн. Ордын орчим гадаргын ус байхгүй, хур тунадас ихтэй үед зарим хөндийд үерийн ус түрж урсаж байдаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Бурхан дэл уурхайн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд байгаль орчин, биологийн хүчин зүйлүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон бүс нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

Хүдрийг ил аргаар олборлон, нуруулдан уусгах технологиор баяжуулах үйл ажиллагаа явуулах төсөл нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй боловч энэ үйл ажиллагааг эхнээс нь зохих журам, стандартыг баримтлан, нарийн хяналт тавьж ажилласан нөхцөлд байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, олборлолтод өртсөн талбайг нөхөн сэргээх ажлыг явуулах боломжтой үйлдвэрлэл гэж үздэг.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсныг доорх хүснэгтэд нэгтгэлээ.

Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Хүснэгт 4. Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

№	Хамрах хүрээ	Дүгнэлт
1	Газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 28.5% нь их сөрөг нөлөөлөлтэй, 42.8% нь дундаж сөрөг нөлөөтэй, 28.5% нь бага сөрөг нөлөөлөлтэй байна.
2	Агаарын чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 22% нь дунд зэрэг, 66 % бага зэрэг, 11% маш баг сөрөг нөлөөлөлтэй байна.
3	Хөрсөнд үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 37.5% нь их зэрэг, 62.5% дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.
4	Усны нөөц, чанарт үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 50% дунд зэрэг, 50 бага зэрэг нөлөөтэй байна.
5	Ургамлын бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн 80% нь дунд зэрэг , 20% бага нөлөөтэй байна.
6	Амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл	нийт нөлөөллийн 50% дунд зэрэг сөрөг нөлөөтэй, 50 бага зэрэг нөлөөтэй байна.
7	Нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл	Нийгэмд нөлөөлөх нөлөөллийн 57% нь эерэг, 43% нь сөрөг нөлөөтэй байна.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу 2025 онд уурхайн бүхий л үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, хамгийн бага түвшинд байлгах, үүсэх эрсдэлийг бууруулах зэрэгт чиглэгдсэн үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу явуулж, үр дүнд хяналт тавин ажиллана, мөн мэргэжлийн байгууллагаар тогтсон хугацаанд хөндлөнгийн хяналтыг хийлгэнэ.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд 2030 он хүртэлх хугацаанд 500 мянган модыг тарихаар төлөвлөжээ.

2025 оны бомт-г хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардлыг 91,380,000 /Ерөн нэгэн сая гурван зуун наян мянган/ төгрөг байхаар төсөвлөсөн бөгөөд үүний 50 хувийг “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10, “ашигт малтмалын тухай” хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д заасны дагуу “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс” буюу төрийн сангийн 100900013406 тоот дансанд байршуулсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт 5. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал (төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15,480,000 ₮
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	20,000,000
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,000,000
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	5,200,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	12,700,000
9	Бомт-г хэрэгжүүлэх тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21,000,000
Нийт		91,380,000

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал Төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт
1. Агаарын чанар									
1	Хүнд даацын машин механизмаас гарах хорт хий агаарын чанарт сөргөөр нөлөөлж агаарыг бохирдуулах	Тээврийн хэрэгслүүдийг жил болгон үзлэг оношилгоонд хамруулах	Төслийн талбай	Төгрөг	30,000	20	600,000	Жил бүр	БОННУ
2		Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй машин техник, хэрэгслүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглүүлэх		-	-	-	Худалдан авалтын гэрээнд тусгасан		
3		Уурхайн олборлолт болон тээвэрлэлт, бутлуурын үед тоос босох		Олборлолт явуулах талбай болон тээвэрлэлтийн зам талбайг услах	-	-	-	Уулын ажлын төсөвт тусгасан	
4	Хүнд даацын машин механизмаас хөдөлгөөний эрчмээс үүдэлтэй тоос тоосонцор орчинд тархах	Хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Төслийн талбай	-	-	-	-	Тогтмол	
5		Үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөлөх хий нэгдэл үүсэх	Үйлдвэрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж агаар дахь синилийн хүчлийг гар багажаар хэмжих	Үйлдвэрийн бүс	-	-	-	Сар бүр	
Дэд дүн, төгрөг					600,000				
2. Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	Орчны бохирдол үүсгэх	Кемпийн ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийн ажиллагаанд хяналт тавих	Төслийн талбай					Улирал бүр	БОННУ
2	Усны нөөц хомсдох	Кемпийн ахуйн бохир усыг цэвэрлэгдэн гарсан усыг замын тоосжилт бууруулах зорилгоор дахин ашиглаж						Сар бүр	БОННУ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

3	Нуруулдан уусгах талбай болон хаягдлын сангаас шүүрэлт нэвчилт үүсэж газар доорх усыг бохирдуулах	Хаягдлын сан болон нуруулдан уусгах талбайгаас нэвчилт шүүрэлт үүсэж буй эсэхэд хяналт тавьж ажиллах	Нуруулдан уусгах байгууламжийн хяналтын цооног	-	-	-	-	Сар бүр	БОННУ
3	Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг жил бүр усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, ус ашиглах дүгнэлтийг жил бүр шинэчлэх		Уурхайн ус ашиглалттай холбоотой бүхий л асуудлууд	Төгрөг	880,000	1	880,000	Жил бүр	Усны тухай хууль
4	Онги-тааз голын сав газрын захиргаанаас ус ашиглуулах зөвшөөрөл жил бүр авч гэрээ байгуулан ажиллах			-	-	-	-		Усны тухай хуулийн 28.6, 29.1
5	Ус бохирдуулсны дүгнэлт авах			-	-	-	-		
6	Ус хангамжийн хоолой, усны тоолуурын бүрэн бүтэн байдал, ажиллагаанд төрийн байгууллагуудтай хамтран байнгын хяналт тавьж ажиллах			Төгрөг	1,000,000	12	12,000,000		Усны тухай хууль
Дэд дүн, төгрөг					12,880,000				
3. Хөрсөн бүрхэвч, газрын хэвлий									
1	Газрын гадарга болон газрын хэвлий эвдэгдэх	Газар хөндөх зөвшөөрлийг уулын ажилд тулгуурлан олгох, газар хөндөлтийг хийхийн өмнө үзлэг хийж, хуулах шимт хөрсний гүнийг тогтоож хяналт тавих	Төслийн талбай	Га	-	-	-	Шинээр газар хөндөх бүрт	БОННУ
2	Олон салаа зам гаргаж хөрсий элэгдэл эвдрэлийг бий болгох	Төлөвлөсөн зам маршрутын дагуу тээвэрлэлт хийх, ашиглалтаас гарсан зам талбайг хаах		-	-	-	-	Тогтмол	БОННУ
3	Машин техникт завсар үйлчилгээ хийх явцад тос, тослох материал асгарч хөрсний бүрхэвчийг бохирдуулах	Зориулалтын засварын газар засвар үйлчилгээг хийх	Төслийн талбай	-	-	-	-	Тогтмол	БОННУ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

4	Химийн бодисын буруу хадгалалт ашиглалтаас болж асгаралт үүсэж хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Химийн бодисыг зориулалтын агуулгахад хадгалах, ашиглалтын явцад асгаралтаас урьдчилан сэргийлж шугам хоолойг тогтмол шалгах	Үйлдвэрийн бүс	-	-	-	-	Улирал бүр	БОННУ
Дэд дүн, төгрөг									
4. Ургамал нөмрөг									
1	Ургамлын байгалийн унаган төрх доройтох	Шинээр газар хөндөлт хийх нөхцөлд ургамлын бүрхэвчийн үзлэгийг хийж, бүрхэц, зүйлийн бүрдлийг тодорхойлох, бүртгэл хийх	Газар хөндөлт хийсэн талбайн хэмжээгээр	Га	-	-	-	Шинээр газар хөндөлт хийх бүрт	БОННУ
Дэд дүн, төгрөг					-				
5. Амьтны аймаг									
1	Амьтдад сөргөөр нөлөөлөх	Зэрлэг амьтан эрсдэх, гэмтэх зэргээс хамгаалах арга хэмжээг авах, хяналт хийх	Төслийн талбай	Төгрөг	200,000	4	800,000	Улирал бүр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаас болж амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Хог хаягдлын тусдаа хогийн цэг байршуулж хашаажуулах, тээвэрлэх явцад байгальд тарахаас сэргийлж хучлагатай машинаар тээвэрлэх	Төслийн талбай	Төгрөг	100,000	12	1,200,000	Сар бүр	
Дэд дүн, төгрөг					2,000,000				
Нийт дүн, төгрөг					15,480,000				

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бурхан дэлийн алтны үндсэн орд нь ашиглалтын 3 дах жилээс ил уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлэх ба нөхөн сэргээлтийн ажлыг тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хийж гүйцэтгэх нь зүйтэй юм.

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөн, өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 56 дугаар тогтоолоор батлагдсан “тонн баялаг-нэг мод” тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өмнөговь аймгийн мандал-овоо сумын нутагт 500,000 мянган модыг 2030 он хүртэл хугацаанд тарьж ургуулна.

Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал Төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт
1	Тэрбум мод үндэсний хөтөлбөрт нэгдэх	Мод, бут сөөг тарих	Мандал- овоо сум	20,000	500	10,000,000	Жил бүр	БОАЖ Сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал 2021.07.09 А/172, 116
2	Зэрлэг ан амьтанг хамгаалах	Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх	Мандал- овоо сум	250 ш	20,000	5,000,000		Амьтны тухай хууль
Нийт дүн, төгрөг				15,000,000				

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал Төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт
1	Нөлөөллийн бүсийн өрх	Шинэ өвөлжөө, бууц дээр байрлуулах	Нөлөөллийн бүсийн айл өрх	1	10,000,000	10,000,000	1 удаа	БОННУ
2	Нөлөөллийн бүсийн өрх	Шинэ өвөлжөө, бууц дээр байрлуулах	Нөлөөллийн бүсийн айл өрх	1	10,000,000	10,000,000	1 удаа	
Нийт дүн, төгрөг				20,000,000				

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй.

Төслийн үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд үйл ажиллагааг түр зогсоож соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлнэ.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал Төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт
1	Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үер, аянга цахилгаан буух, шороон шуурга, гал түймэр болох	Цаг, агаар гамшгийн үеийн мэдээллийг тогтмол авч үйл ажиллагаа уялдуулж ажиллах	Төслийн талбай	-	-	-	Сар бүр	БОННУ
2		Гал гарсан тохиолдолд хэрэглэх галын иж бүрдлийг бэлэн байлгах		10	100,000	1,000,000,	Улирал бүр	
3	Үйл ажиллагааны явцад технологийн горим алдагдах гэнэтийн авар ослыг улмаас химийн бодис алдагдах	Баяжуулах үйлдвэрийн хэвийн ажиллагааг байнга шалгаж, болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлж хянаж, шалгаж байх	Үйлдвэрийн бүс	-	-	-	Сар бүр	БОННУ
4		Хаягдлын далан, нуруулдан уусгах байгууламжийн нэвчилт, шүүрэлт явагдаж буй эсэхэд тогтмол хяналт, тавьж ажиллах.		-	-	-	Сар бүр	БОННУ
5		Баяжуулах үйлдвэр доторх агаарын хийн агууламжийг илрүүлдэг мэдрэгчтэй багажийн бүрэн бүтэн байдлыг шалгах		-	-	-	Сар бүр	БОННУ
6	Хаягдлын далан, нур, уусмалын цөөрөмд амьтан унах, хордох	Нуруулдан уусгах талбай хаягдлын далангийн шувуу үргээгч төхөөрөмжийг тогтмол ажиллуулах	Нуруулдан усгах талбайн байгууламж	10	100,000	1,000,000	Сар бүр	Амьтны тухай хууль
7	Гэнэтийн осол аваар гарах	Уурхайн нийт ажилчдад хабза сургалт зохион байгуулж, уурхайн эрсдэлийн менежментийн дагуу ажиллах	Төслийн талбай	-	-	-	Улирал бүр	БОННУ
Нийт дүн, төгрөг				2,000,000				

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар хог хаягдлын дахин эргэлтэд оруулах бодлогыг баримтлан ажиллана.

Хүснэгт 10.

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал Төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт
1	Энгийн хог хаягдал	Хог хаягдлын бүртгэл хөтлөх	Төслийн талбай	-	-	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдлыг ангилан ялгах	Төслийн талбай	-	-	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
3		Хог хаягдлыг хогийн цэгт булшлах	Мандал овоо сумын хогийн цэг	М ³	100,000	12	1,200,000	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
4		Хог хаягдлыг түр цуглуулах цэгийг ариутгах	Төслийн талбай	-	-	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
5	Аюултай хог хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлыг хаягдлыг бүртгэх	Химийн бодисын агуулах	Кг	-	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
6		Аюултай хаягдлыг эрх бүхий байгууллагад гэрээний дагуу шилжүүлэх	Төслийн талбай	Тн	1,000,000	4	4,000,000	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль
7		Тос тослох материалаар бохирдсон хөрсийг саармагжуулах талбайд байршуулах	Төслийн талбай	М ³	-	-	-	Сар бүр	БОННУ
8		Хог хаягдлыг зориулалтын талбайд хадгалах	Төслийн талбай	-	-	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
Нийт дүн, төгрөг							5,200,000		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 11.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал Төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт
1. Агаарын чанар								
1	Тоосны хэмжилт Pm2.5, pm10, нийт тоос	1. Ил уурхайн олборлолтын орчимд 2. Тээвэрлэлтийн замын орчимд 3. Баяжуулах үйлдвэрийн орчим 4. Ажилчдын хотхон 5. Тэсэлгээний агуулахын орчимд 6. Худаг 7. Харьцуулалтын цэг	24 цаг	Улирал бүр 1 удаа	-	-	Дотоодын багажаар хэмжилт хийх	MNS 4585:2016 Агаарын чанар,
2	Агаарын чанарын үзүүлэлт No ₂ , So ₂ , co	1. Баяжуулах үйлдвэрийн орчим 2. Засварын газрын ойр орчим 3. Ажилчдын хотхоны уурын зуух 4. Аюултай хог хаягдлын түр цэг 5. Түлшний агуулах 6. Авто машины зогсоолын талбай	20 минут	Улирал бүр 1 удаа	50,000	1,200,000		
3	Синилийн хүчил Hcp	1. Нуруулдан уусгах талбай 2. Химийн бодисын агуулах 3. Хаягдлын далангийн 4. Баяжуулах үйлдвэр 5. Химийн лаборатори	20 минут	Улирал бүр 1 удаа	-	-	Дотоодын багажаар хэмжилт хийх	
Дэд дүн төгрөг					1,200,000			
2. Гадаргын ба газрын доорх усны нөөц								
1	Ерөнхий химийн болон хүнд металлын шинжилгээ	1. Хяналтын цооногууд 2. Ашиглалтын худаг 3. Цэвэрлэх байгууламж	Улирал бүр	1 удаа	125,000	1,500,000	Дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэх	MNS 0900:2018 Ундны ус эрүүл ахуйн шаардлага MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ
2	Микробиологийн шинжилгээ	1. Ашиглалтын худаг 2. Цэвэрлэх байгууламж	Улирал бүр	1 удаа	75,000	600,000		MNS 4943:2015 Хаягдал ус,
Дэд дүн, төгрөг					2,100,000			

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

3. Хөрсөн бүрхэвч

1	Агрохимийн шинжилгээ	1. Шимт хөрсний овоолго 2. Хөндөгдөөгүй талбай	Жил бүр	1 удаа	100,000	200,000	Дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэх	MNS 3310:1991 Хөрсний агрохимийн үзүүлэлт
2	Хүнд металлын шинжилгээ	1. Үйлдвэрийн орчим 2. Хаягдлын далангийн баруун талд 3. Хаягдлын далангийн зүүн талд 4. Нуруулдан уусгах талбайн урд талд 5. Нуруулдан уусгах талбайн хойд талд 6. Химийн бодисын агуулах 7. Түлшний агуулах 8. Шатахуун түгээх станцын ойр орчим 9. Тээвэрлэлтийн зам 10. Хөндөгдөөгүй талбай	Улирал бүр	1 удаа	200,000	8,000,000		MNS 5850:2018 Хөрсний чанар
3	Микробиологийн шинжилгээ	1. Цэвэрлэх байгууламжийн ойр орчим 2. Ажилчдын хотхон 3. Шимт хөрс	Улирал бүр	1 удаа	100,000	1,200,000		MNS 3297:1991 Хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ
Дэд дүн, төгрөг				9,400,000				
4. Ургамлын мониторинг								
1	Ургамлын судалгаа хийх	Төслийн талбайн ойр орчим	Ургалтын үед	1 удаа	-	-	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардалд багтсан	
Дэд дүн, төгрөг				-				
5. Амьтны судалгаа								
1	Зэрлэг ан амьтны судалгаа хийх	Төслийн талбайн ойр орчим	Жилд	1 удаа	-	-	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардалд багтсан	
Дэд дүн, төгрөг				-				
Нийт дүн, төгрөг				12,700,000				

**13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Мандал ресурс” ххк-ийн байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, бохт, бохшх-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025				
			Cap	Cap	Cap		
1	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	10,000,000	8			ХЭМАБ-БОХ-н захирал А.Цэрэнтогтох	Байгаль хамгаалах тухай хууль
2	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх	10,000,000		7			
3	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	1,000,000			6		
Нийт дүн, төгрөг			21,000,000				

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

"Мандал ресурс" ххк нь жил бүр бомт-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Бомт-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 13. Бомт-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Бомт-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Өмнөговь аймгийн байгаль орчны газар	Уулзалт, санал асуулга	Бомт болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Дотоод төлөвлөлтөөр	"Мандал ресурс" ХХК	Өмнөговь аймгийн мандал-овоо сум
2	БОУАӨЯ-НЫ ХБОБНУГ-Т	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	Дараа оны 1 дүгээр сард	Дотоод төлөвлөлтөөр	"Мандал ресурс" ХХК	-
3	Багийн иргэд нийтийн хурал болон байгаль орчны байцаагч	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн бомт-ий хэрэгжилтийн талаар	Жилд 1 удаа	Дотоод төлөвлөлтөөр	"Мандал ресурс" ХХК	Багийн төв